

**УИХ-ЫН ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ ДАХЬ САНАЛ ХУРААЛТЫГ  
ЦАХИМ ТООЛУУРААР ЯВУУЛАХ ЗОХИЦУУЛАЛТ БА ГИШҮҮДИЙН ИРЦ**

(Харьцуулсан судалгаа)

*Г.Билгээ, И.Жаргалзаяабямба*

**АГУУЛГА**

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

1. УИХ-ын дэгийн тухай хууль тогтоомжийн тойм
2. Санал хураалтыг цахим тоолуураар явуулах зохицуулалтын тойм
3. Цахим санал хураалт ба УИХ-ын гишүүдийн ирц
  - 3.1. УИХ-ын хуралдааны дэгийн тухай хууль (1997)
  - 3.2. УИХ-ын хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан (2010)
  - 3.3. УИХ-ын хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан (2018)

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдан ажилласан 30 гаруй жилийн түүхэндээ дэгтэй холбоотой Монгол Улсын 3 хууль, Улсын Их Хурлын болон Улсын Бага хурлын 3 тогтоолыг баталж байжээ.

УИХ-ын санал хураах журамд цахим тоолуур ашиглах тухай эрх зүйн анхны зохицуулалтыг 1997 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуульд тусгасан байна. Үүний дараа хуралдааны дэгийг УИХ-ын 2001 оны 61, 2006 оны 14 дүгээр тогтоолоор шинэчлэн батлахдаа санал хураалтыг цахим тоолуураар явуулахыг хэвээр үлдээжээ. Гэвч одоо мөрдөж буй Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг анх 2007 онд батлахдаа дээрх зохицуулалтыг оруулаагүй байсныг 2010 онд нэмж оруулсан; мөн 2018 онд хурууны хээгээр хуралдааны ирцэд бүртгүүлэх, асуулт асуух, үг хэлэх, санал өгөхөөр шинээр оруулсан байна.

Судалгааны ажлыг гүйцэтгэх явцдаа УИХ-ын архивт байгаа дээрх хууль тогтоомжуудын хувийн хэргийг судалж үзэхэд санал хураалтыг цахим тоолуураар явуулах үндэслэл шаардлагыг дурдаагүй байна.

Судалгааны явцад санал хураалтыг цахим тоолуураар явуулснаар УИХ-ын гишүүдийн чуулганы хуралдааны ирцэд хэрхэн нөлөөлснийг зарим үзүүлэлтээр харьцуулан авч үзлээ: УИХ-ын гишүүдийн хуралдааныг тасалсан өдөр (цаг) нь чуулганы нэгдсэн худалдаан хуралдсан өдөр (цаг)-т эзлэх хувийг тооцон үзвэл дараах үр дүн гарч байна. Үүнд:

- 1997 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд гишүүдийн тасалсан цагийн нийлбэрийг 1996 оны намрын ээлжит чуулгантай харьцуулахад **нэг хувиар буурсан;**
- 2010 оны хаврын ээлжит чуулганыг 2009 оны намрын ээлжит чуулгантай харьцуулахад **гишүүдийн хуралдаан тасалсан үзүүлэлт нь 7 хувиар өссөн;**
- 2019 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд гишүүдийн бүртгэлд ороогүй буюу тасалсан өдрийн нийлбэр нь 2018 оны намрын ээлжит чуулгантай харьцуулахад **нэг хувиар өссөн байна.**

УИХ.МН  
СУДАЛГААНЫ САН

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

### 1. УИХ-ЫН ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТОЙМ<sup>166</sup>

Монгол Улсын байнгын ажиллагаатай парламент байгуулагдсан цагаасаа хойш хуралдааны дэгээ 6 удаа шинэчлэн баталсан бөгөөд аливаа асуудлыг хамтран хэлэлцэж олонхоороо шийдвэрлэхдээ баримтлах журмаа илүү тодорхой болгохоор ажиллаж байсан.

Монгол Улсын парламентын хуралдааны анхны дэгийг БНМАУ-ын Бага Хурлаас 1990 оны 01 дүгээр тогтоолоор “БНМАУ-ын Бага Хурлын анхдугаар чуулганы дэг”<sup>167</sup> нэртэйгээр баталж байжээ.

Үүний дараа 1992 онд Улсын Бага Хурлаас Монгол Улсын Их Хурлын тухай хуулийг баталсан байна. Энэ хуулийн 6-9 дүгээр бүлгүүдэд<sup>168</sup> УИХ-ын чуулганы хуралдааны дэгтэй холбоотой зохицуулалтыг тусгаж нэлээд өргөн агуулгатай болгосон: нэг талаас УИХ, түүний гишүүдийн эрх зүйн байдлыг тодорхой болгож, нөгөө талаас УИХ-ын чуулганы хуралдааны дэгийг бүхэлд нь зохицуулсан агуулгатай болгосон. Ингэснээр Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан УИХ-ын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг тодорхой болгож нарийвчлан зохицуулсан байна.

УИХ-ын 2 дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан парламент (1996-2000) өмнөх парламентад үйлчилж байсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийг хүчингүй болгож, Монгол Улсын Их Хурлын тухай хуулиас гадна Монгол Улсын Их Хурлын чуулган хуралдааны дэгийн тухай хуулийг шинээр баталжээ. Энэ үеэс Монголын парламентад 1997 оноос хойш Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан журмыг хоёр хуулиар зохицуулж эхэлсэн байна.

УИХ-ын 3 дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан парламент (2000-2004) дэгийн асуудлыг УИХ-ын тогтоолоор зохицуулахаар шийдвэрлэж, “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай” УИХ-ын 2001 оны 61 дугаар тогтоолыг батлан гаргажээ.

Дэгийн зохицуулалтыг шинэчлэх болсон гол шалтгаан нь 2000 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотой. Хуулийн төслийн танилцуулгад *“УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ баримтлах дэг (журам)-ээ хуулиар тогтоож байсан. Энэ асуудлыг ажлын хэсэг авч үзэж өмнө нь мөрдөж байсан хууль, тогтоол, гадаад орнуудын туршлага зэргийг судлан үзсэний үндсэн дээр эрх зүйн талаасаа ямар хэлбэрийн эрхийн актаар зохицуулах*

<sup>166</sup>Парламентын хуралдааны дэгийн онол, арга зүйн үндэс. Л.Өлзийсайхан. УБ., 2010 он. 54-59 дэх тал.

<sup>167</sup>БНМАУ-ын Бага Хурлын 1990 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн “Дэг батлах тухай” 1 дүгээр тогтоол. Эх сурвалж: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (1990-2017 он). Ерөнхий редактор Ц.Цолмон. УБ., 2018. 208-214 дэх тал.

<sup>168</sup>Монгол Улсын Их Хурлын тухай хууль:

Зургадугаар бүлэг - Улсын Их Хурлын чуулганы хуралдаан;

Долдугаар бүлэг - Тодорхой асуудал хэлэлцэж шийдвэрлэх;

Наймдугаар бүлэг - Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл хянан хэлэлцэх, батлах;

Есдүгээр бүлэг - Улсын Их Хурал шийдвэр гаргах, түүнийг нийтлэх журам.

нь илүү тохиромжтойг анхаарсан. Улсын Бага Хурал энэ асуудлаа хуулиар биш тогтоолоор баталж мөрдөж байсан. Мөн гадаадын ихэнх орнууд энэ асуудлаа тодорхой дүрэм, журмаар тогтоон мөрдүүлж байна” гэж дурдсан байна.<sup>169</sup>

Хүснэгт 1. УИХ-ын дэгийн тухай хууль тогтоомжийн жагсаалт<sup>170</sup>

	Баримт бичгийн нэр	Баталсан огноо (дугаар)	Нэмэлт, өөрчлөлт орсон огноо (дугаар)	Хүчингүй болсон огноо (дугаар)
1.	Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлын анхдугаар чуулганы дэг	“Дэг батлах тухай” БНМАУ-ын Бага хурлын тогтоол, 1990.09.13, №01	БНМАУ-ын Бага хурлын тогтоол, 1990.11.12, №29	
2.	Монгол Улсын Их Хурлын тухай	Монгол Улсын хууль, 1992.07.06		1997.02.06-ны хуулиар
3.	<b>Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэг</b>	<b>Монгол Улсын хууль, 1997.02.06</b>	1997.05.22, 1997.06.13, 1997.07.04, 1998.01.08, 1999.01.22-ны хуулиудаар	2001.06.21-ний хуулиар
4.	Монгол Улсын Их Хурлын чуулганы дэг	“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай”, УИХ-ын тогтоол, 2001.06.21, №61	2001.11.08-ны №82, 2004.05.13-ны №29 УИХ-ын тогтоолуудаар	УИХ-ын тогтоол, 2006.01.27, №14
5.	Монгол Улсын Их Хурлын чуулганы дэг	“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай”, УИХ-ын тогтоол, 2006.01.27, №14		УИХ-ын тогтоол, 2007.10.11, №67
6.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай	Монгол Улсын хууль, 2007.10.11	2008.12.04, 2009.06.11, 2009.07.03, <b>2010.12.30</b> , 2011.01.20, 2011.12.23, 2012.08.17, 2012.12.21, 2012.12.21, 2014.10.16, 2015.01.29, 2015.05.29, 2015.07.08, 2016.01.19, 2016.04.14, 2016.12.01, 2017.01.12, 2017.05.12, 2017.11.10, 2017.11.23, 2018.06.29, 2019.01.18-ны хуулиудаар	

<sup>169</sup> УИХ-ын Тамгын газрын архив. Данс 5, ХН 288.

<sup>170</sup> Эх сурвалж:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль 1990-2017 он (Эх сурвалж, харьцуулсан судалгаа). Ерөнхий редактор Ц.Цолмон. УБ., 2018.

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://www.legalinfo.mn/additional/?lawid=356>

УИХ-ын 4 дэх удаагийн сонгуулиар байгуулагдсан парламент (2004-2008) дэгийн зохицуулалтыг 2 удаа шинэчилжээ. 2006 онд “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай” УИХ-ын 14 дүгээр тогтоолыг, 2007 онд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг тус тус баталжээ. 2007 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг өнөөг хүртэл буюу байнгын ажиллагаатай парламентын түүхэнд хамгийн удаан даган мөрдөж байна.

## 2. САНАЛ ХУРААЛТЫГ ЦАХИМ ТООЛУУРААР ЯВУУЛАХ ЗОХИЦУУЛАЛТЫН ТОЙМ

УИХ-ын санал хураах журамд цахим тоолуур ашиглах тухай эрх зүйн анхны зохицуулалтыг 1997 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуульд тусгасан байна. Үүний дараа УИХ-ын тогтоолоор “Монгол Улсын Их Хурлын чуулганы дэг”-ийг 2 удаа шинэчлэн батлагдахад санал хураалтыг цахим тоолуураар явуулах зохицуулалтыг хэвээр үлдээжээ.

Одоо мөрдөж байгаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг анх 2007 онд батлахдаа санал хураалтын цахим тоолуурын талаар зохицуулалт оруулаагүй байсныг 2010 оны Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар өөрчилж, “Санал хураалт явуулах ерөнхий журам” гэсэн 9<sup>1</sup> дүгээр зүйлийг нэмж оруулан санал хураалтыг цахим тоолуураар явуулахаар тусгажээ.

Хүснэгт 2. Дэгийн тухай хууль тогтоомжуудад тусгасан санал хураалтыг цахим тоолуураар явуулах зохицуулалт<sup>171</sup>

Монгол Улсын хууль <b>Монгол Улсын Их Хурлын чуулганы дэг</b> 1997.02.06	УИХ-ын тогтоол <b>Монгол Улсын Их Хурлын чуулганы дэг</b> 2001.06.21, №01	УИХ-ын тогтоол <b>Монгол Улсын Их Хурлын чуулганы дэг</b> 2006.01.27, №14	Монгол Улсын хууль <b>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай</b> 2007.10.11
<b>41 дүгээр зүйл. Санал хураалт, түүнийг явуулах журам</b>  4. Үндсэн хууль, энэ хууль болон, бусад хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд санал хураалт явуулахдаа хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар уг асуудлыг шийдвэрлэнэ.	<b>Хорин тав. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд санал хураалт явуулах журам</b>  25.2. Үндсэн хууль, бусад хууль болон энэ дэгд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд санал хураалт явуулахдаа хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар уг асуудлыг шийдвэрлэнэ.	<b>Хорь. Нэгдсэн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлэг явуулах</b>  20.3.4. ил санал хураалтыг санал хураах хуудсаар, эсхүл <u>цахим тоолуураар</u> явуулах.	<b>9<sup>1</sup> дүгээр зүйл. Санал хураалт явуулах ерөнхий журам</b>  9 <sup>1</sup> .2. Ил санал хураалтыг гар өргөж, эсхүл <u>цахим тоолуураар</u> , нууц санал хураалтыг санал хураах хуудсаар, эсхүл <u>цахим тоолуураар</u> явуулна. Хуралдааны ирцэд бүртгүүлэх, асуулт асуух, үг хэлэх, <u>цахим тоолуураар санал өгөхөд биеийн давхцахгүй өгөгдөл / гарын хурууны хээ/- өөр идэвхждэг систем бүхий цахим тоолуурыг</u> ашиглана.

<sup>171</sup>Эх сурвалж: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль 1990-2017 он. Ерөнхий редактор Ц.Цолмон. УБ., 2018. 313, 337-338 дахь тал.

<p>Энэ хууль болон бусад хуульд нууц санал хураалт явуулж шийдвэрлэхээр зааснаас бусад тохиолдолд санал хураалтыг илээр явуулна. <b>Ил санал хураалтыг гар өргөж, эсхүл цахим тоолуураар, харин нууц санал хураалтыг санал хураах хуудсаар, эсхүл цахим тоолуур ашиглан явуулна.</b></p>	<p>Үндсэн хууль, бусад хуульд нууц санал хураалт явуулж шийдвэрлэхээр зааснаас бусад тохиолдолд санал хураалтыг илээр явуулна. <b>Ил санал хураалтыг гар өргөж, эсхүл цахим тоолуураар, харин нууц санал хураалтыг санал хураах хуудсаар, эсхүл цахим тоолуур ашиглан явуулна.</b></p>		<p>9<sup>1</sup>.3.Санал хураах хуудас ашиглан нууц санал хураалт явуулах бол Улсын Их Хурлын гишүүдээс бүрдсэн тооллогын комисс байгуулан санал хураалт явуулж, дүнг танилцуулна.</p> <p>9<sup>1</sup>.4.Цахим тоолуураар нууц санал хураалт явуулах бол зөвхөн санал хураалтын дүн гарах бөгөөд санал өгсөн гишүүдийн нэрс цахим тоолуурын системд хадгалагдахгүй.</p> <p>9<sup>1</sup>.5.Санал хураалт явуулах үед гишүүн санал өгөх эрхээ зөвхөн өөрөө эдлэх бөгөөд энэхүү эрхээ бусдад шилжүүлэх, бусад гишүүний өмнөөс санал өгөхийг хориглоно.</p>
--	--	--	---

Дээрх хууль тогтоомжийн төслийн архивын хувийн хэргийг үзэхэд санал хураалтыг цахим тоолуураар явуулах үндэслэл, хэрэгцээ шаардлагыг дурдаагүй байна.<sup>172</sup>

1997 оноос хойш Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд 21 удаа нэмэлт, өөрчлөлт орж байжээ. 2018 онд энэ хуулийн 9<sup>1</sup> дүгээр зүйлийн 9<sup>1</sup>.2 дахь хэсэгт гарын хурууны хээгээр хуралдааны ирцэд бүртгүүлэх, асуулт асуух, үг хэлэх, санал өгөхийг цахим болгон өөрчилснийг 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс мөрдөж эхлээд байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2018.06.29)-ийн танилцуулгад: “УИХ-ын гишүүний хариуцлагыг нэмэгдүүлэх замаар УИХ-ын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд хуралдааны ирцэд бүртгүүлэх, асуулт асуух, үг хэлэх, цахим тоолуураар санал өгөхөд биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-өөр идэвхждэг систем бүхий цахим тоолуурыг ашиглах, гишүүн чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанд оролцсон ирцийн мэдээг сар бүр гаргаж, олон нийтэд мэдээлэх, гишүүн нэгдсэн хуралдаанд хүндэтгэн үзэх

<sup>172</sup>Тайлбар:

1997 оны 02 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн архивын хувийн хэрэгтэй танилцахад энэ хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга байхгүй байв. (УИХ-ын Тамгын газрын архив, Данс 4, ХН 207)

УИХ-ын “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай” 2001 оны 61 дүгээр тогтоолын архивын хувийн хэрэгтэй танилцахад энэ тогтоолын төслийн үзэл баримтлал байгаагүй, харин танилцуулгад санал хураалтыг цахим тоолуураар явуулах үндэслэл шаардлагыг дурдаагүй байв. (УИХ-ын Тамгын газрын архив, Данс 5, ХН 288)

УИХ-ын “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай” 2006 оны 14 дүгээр тогтоолын архивын хувийн хэрэгтэй танилцахад энэ тогтоолын төслийн үзэл баримтлал, танилцуулгад санал хураалтыг цахим тоолуураар явуулах үндэслэл шаардлагыг дурдаагүй байв. (УИХ-ын Тамгын газрын архив, Данс 6, ХН 739)

2010 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн архивын хувийн хэрэгтэй танилцахад энэ хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга байхгүй байв. (УИХ-ын Тамгын газрын архив, Данс 7, ХН 812)

шалтгаангүйгээр оролцоогүй бол тасалсан өдрийн цалинг олгохгүй байх, гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолгүй асуудлаар үг хэлбэл хуралдаан даргалагч нэг удаа сануулах, сануулгыг зөрчвөл тухайн үг хэлэх хугацааг дуусгавар болгох зохицуулалтуудыг шинээр тусгасан. Хууль батлагдсанаар УИХ-ын гишүүний хариуцлага нэмэгдэх хууль зүйн зэрэг үр дүн гарч, цаашлаад хууль тогтоомжийн чанар сайжрах, тогтвортой байхад сайнаар нөлөөлөх ач холбогдолтой”<sup>173</sup> гэсэн байна.

### 3. ЦАХИМ САНАЛ ХУРААЛТ БА УИХ-ЫН ГИШҮҮДИЙН ИРЦ

Судалгааны энэ хэсэгт санал хураалтыг цахим тоолуураар явуулах тухай эрх зүйн зохицуулалт нь УИХ-ын гишүүдийн ирцэд хэрхэн нөлөөлснийг тодорхой хугацааны үечлэлээр авч үзсэн болно. Ингэхдээ гишүүдийн тасалсан өдрийн тоо (цаг)-г нэгдсэн худалдааны тоо (цаг)-той харьцуулж гаргасан болно. Статистик үзүүлэлтийг цахим санал хураалт анх зохицуулсан **1997 оны хууль**, нэмж оруулсан **2010 оны хууль** болон гарын хурууны хээгээр идэвхждэг систем бүхий цахим тоолуурыг ашиглахаар **шинээр тусгасан 2018 оны хууль** хэрэгжиж эхэлсэн тухайн ээлжит чуулганы ирцийн мэдээг түүний өмнөх ээлжит чуулганы ирцийн мэдээтэй харьцуулж гаргалаа.

Хүснэгт 3. Эрх зүйн орчин ба харьцуулалт хийсэн хугацаа

	Баримт бичгийн нэр (баталсан огноо)	Тайлбар	Харьцуулалтад хамрагдах хугацаа
1.	Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хууль (1997.02.06)	Санал хураалтыг цахим тоолуураар явуулахаар (анх удаа зохицуулсан)	<ul style="list-style-type: none"> <li>• 1996 оны намрын ээлжит чуулган</li> <li>• 1997 оны хаврын ээлжит чуулган</li> </ul>
2.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (2007)-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2010.12.30)	Санал хураалтыг цахим тоолуураар явуулахаар (нэмж оруулсан)	<ul style="list-style-type: none"> <li>• 2009 оны намрын ээлжит чуулган</li> <li>• 2010 оны хаврын ээлжит чуулган</li> </ul>
3.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (2007)-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2018.06.29)	Хуралдааны ирцэд бүртгүүлэх, асуулт асуух, үг хэлэх, цахим тоолуураар санал өгөхөд биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-өөр идэвхждэг систем бүхий цахим тоолуурыг ашиглахаар (шинээр тусгасан)	<ul style="list-style-type: none"> <li>• 2018 оны намрын ээлжит чуулган</li> <li>• 2019 оны хаврын ээлжит чуулган (2019.04.05-26)</li> </ul>

#### 3.1. УИХ-ын хуралдааны дэгийн тухай хууль (1997)

УИХ-ын 2 дахь удаагийн сонгуулийн 1996 оны намрын ээлжит чуулган 1996 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр нээгдэж, 1997 оны 02 дугаар сарын 06-ны өдрийг дуустал ажлын 107 хоног үргэлжилж, энэ хугацаанд нэгдсэн хуралдаан 36 өдөр, 200 цаг үргэлжлэн хуралджээ.<sup>174</sup>

<sup>173</sup>Монгол Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганы үйл ажиллагааны танилцуулга. УБ., 2018. 101 дэх тал.

<sup>174</sup>УИХ-ын 1996 оны намрын чуулганы дүнгийн тухай танилцуулга. УИХ-ын Тамгын газрын архив, Данс 4, ХН 336.



УИХ-ын 1997 оны хаврын ээлжит чуулган 1997 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс 07 дугаар сарын 09-ний өдрийг дуустал ажлын 82 хоног үргэлжилсэн бөгөөд энэ хугацаанд нэгдсэн хуралдаан 24 өдөр, 144 цаг үргэлжлэн хуралдсан байна.<sup>175</sup>

Энэхүү хоёр чуулганы танилцуулгад УИХ-ын гишүүдийн ирцийн зөвхөн “өвчтэй, чөлөөтэй, тасалсан, хоцорсон” цаг, минутыг оруулжээ. Санал хураалтыг цахим тоолуураар явуулсан 1997 оны хаврын ээлжит чуулганы гишүүдийн тасалсан цагийн нийлбэрийг өмнөх 1996 оны намрын ээлжит чуулгантай харьцуулахад нэг хувиар буурсан байна.

*Хүснэгт 4. УИХ-ын гишүүдийн ирцийн тойм<sup>176</sup>  
(УИХ-ын 1996 оны намар, 1997 оны хаврын ээлжит чуулган)*

Үзүүлэлтүүд	1996 оны намрын ээлжит чуулган (1996.09.30-1997.02.06)		1997 оны хаврын ээлжит чуулган (1997.04.05-07.09)		Зөрүү
	Нийлбэр цаг	Эзлэх хувь	Нийлбэр цаг	Эзлэх хувь	
Хуралдсан байдал	200:00	100%	144:00	100%	
Гишүүдийн хуралдааныг					
- тасалсан цаг	537:50	4%	332:15	3%	1% ↓

### **3.2. УИХ-ын хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан (2010)**

УИХ-ын 2010 оны намрын ээлжит чуулганы хуралдаан 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдрийг дуустал ажлын 92 өдөр үргэлжилж нэгдсэн хуралдаан 37 удаа, 155 цаг 46 минут үргэлжлэн хуралдсан байна.<sup>177</sup>

УИХ-ын 2011 оны хаврын ээлжит чуулган 04 дүгээр сарын 05-ны өдрөөс 07 дугаар сарын 09-ний өдрийг дуустал ажлын 69 өдөр үргэлжилсэн ба нэгдсэн хуралдаан 42 удаа, 116 цаг 11 минут үргэлжлэн хуралджээ.<sup>178</sup>

Ээлжит хоёр чуулганы танилцуулгад “хуралдсан дүн”, УИХ-ын гишүүдийн “хуралдаанд оролцсон болон оролцоогүй дүн, гадаад болон орон нутагт ажилласан, чөлөөтэй, өвчтэй, тасалсан, хоцорсон дүн”-г цаг, минут, өдрөөр гаргасан байна.

<sup>175</sup>УИХ-ын 1997 оны хаврын чуулганы дүнгийн тухай танилцуулга. УИХ-ын Тамгын газрын архив, Данс 4, ХН 399.

<sup>176</sup>Эх сурвалж:

-УИХ-ын 1996 оны намрын чуулганы дүнгийн тухай танилцуулга. УИХ-ын Тамгын газрын архив, Данс 4, ХН 336.

-УИХ-ын 1997 оны хаврын чуулганы дүнгийн тухай танилцуулга. УИХ-ын Тамгын газрын архив, Данс 4, ХН 399.

<sup>177</sup>Улсын Их Хурлын 2010 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагааны талаарх нэгдсэн танилцуулга. УБ., 2011 он. 14, 169 дэх талууд.

<sup>178</sup>Улсын Их Хурлын 2011 оны хаврын ээлжит чуулганы үйл ажиллагааны талаарх нэгдсэн танилцуулга. УБ., 2011 он. 13, 120 дахь тал.



2010 оны хаврын ээлжит чуулганы гишүүдийн хуралдаан тасалсан үзүүлэлт нь өмнөх 2009 оны намрын ээлжит чуулгантай харьцуулахад 7 хувиар өссөн байна.

*Хүснэгт 5. УИХ-ын гишүүдийн ирцийн тойм<sup>179</sup>  
(УИХ-ын 2009 оны намар, 2010 оны хаврын ээлжит чуулган)*

Үзүүлэлтүүд	2009 оны намрын ээлжит чуулган (2010.10.01-2011.02.10)		2010 оны хаврын ээлжит чуулган (2011.04.05-07.09)		Зөрүү
	Нийлбэр өдрийн тоо	Эзлэх хувь	Нийлбэр өдрийн тоо	Эзлэх хувь	
Хуралдсан байдал	37	100%	27	100%	
Гишүүдийн хуралдаанд					
- оролцсон байдал	1936	70%	1364	66%	4%↓
- оролцоогүй	814	30%	688	34%	4%↑
Үүнээс:					
- тасалсан	207	7%	291	14%	7%↑

### **3.3. УИХ-ын хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт ороулсан (2018)**

УИХ-ын 2018 оны намрын ээлжит чуулган 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийг дуустал ажлын 88 өдөр үргэлжилсэн. Чуулганы хугацаанд нэгдсэн хуралдаан 31 удаа, 121 цаг 06 минут үргэлжлэн хуралдсан байна.<sup>180</sup>

УИХ-ын 2019 оны хаврын ээлжит чуулганы хувьд нэгдсэн мэдээ гараагүй тул УИХ-ын цахим хуудаст байршуулсан нэгдсэн хуралдааны тэмдэглэлийг эх сурвалжаа болгож авсан. Судалгаанд 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс 26-ны өдрийг<sup>181</sup> хүртэлх ажлын 16 өдрийн мэдээг хамруулсан болно. Энэ хугацаанд нэгдсэн хуралдаан 6 удаа 25 цаг 38 минут үргэлжлэн хуралджээ.<sup>182</sup>

Харьцуулалтад хамрагдаж байгаа хоёр чуулганы танилцуулгыг үзэхэд УИХ-ын гишүүдийн ирцийн мэдээнд “тасалсан” гэснийг “бүртгэлд ороогүй” гэж өөрчилсөн байна. УИХ-ын 2019 оны хаврын ээлжит чуулганы хуралдаанд гишүүдийн бүртгэлд ороогүй (эсхүл тасалсан) өдрийн нийлбэр нь өмнөх 2018 оны намрын ээлжит чуулгантай харьцуулахад 1 хувиар өссөн байна.

<sup>179</sup>Эх сурвалж:

- Улсын Их Хурлын 2010 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагааны талаарх нэгдсэн танилцуулга. УБ., 2011 он. 120-125 дахь тал.  
- Улсын Их Хурлын 2011 оны хаврын ээлжит чуулганы үйл ажиллагааны талаарх нэгдсэн танилцуулга. УБ., 2011 он. 169-174 дэх тал.

<sup>180</sup>Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагааны талаарх нэгдсэн танилцуулга. УБ., 2019 он. 13 дахь тал.

<sup>181</sup>2019 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар.

<sup>182</sup>Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 05, 11, 12, 18, 19, 26-ны өдрүүдийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл. Эх сурвалж: [www.parliament.mn](http://www.parliament.mn)

**Хүснэгт 6. УИХ-ын гишүүдийн ирцийн тойм<sup>183</sup>**  
**(УИХ-ын 2018 оны намар, 2019 оны хаврын ээлжит чуулган)**

Үзүүлэлтүүд	<b>2018 оны намрын ээлжит чуулган</b> (2018.10.01-2019.02.02)		<b>2019 оны хаврын ээлжит чуулган</b> (2019.04.05-26)		Зөрүү
	Нийлбэр өдрийн тоо	Эзлэх хувь	Нийлбэр өдрийн тоо	Эзлэх хувь	
Хуралдсан байдал	31	100%	6	100%	
Бүртгэлд ороогүй (тасалсан) тоо	183	8%	42	9%	<b>1% ↑</b>

**UIH.MN**  
**СУДАЛГААНЫ САН**

<sup>183</sup>Эх сурвалж:

- Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагааны талаарх нэгдсэн танилцуулга. УБ., 2019 он. 139-140 дэх тал.
- Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 05, 11, 12, 18, 19, 26-ны өдрүүдийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл. Эх сурвалж: [www.parliament.mn](http://www.parliament.mn)

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

## Ном, товхимол

- Монгол Улсын байнгын ажиллагаатай парламентын Тамгын газар (1990-2015 он). Ерөнхий редактор Б.Болдбаатар. УБ., 2015.
- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль 1990-2017 он (Эх сурвалж, харьцуулсан судалгаа). Ерөнхий редактор Ц.Цолмон. УБ., 2018.
- Парламентын хуралдааны дэгийн онол, арга зүйн үндэс. Л.Өлзийсайхан. УБ., 2010 он.
- Монгол Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганы үйл ажиллагааны танилцуулга. УБ., 2018.
- Улсын Их Хурлын 2010 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагааны талаарх нэгдсэн танилцуулга. УБ., 2011 он.
- Улсын Их Хурлын 2011 оны хаврын ээлжит чуулганы үйл ажиллагааны талаарх нэгдсэн танилцуулга. УБ., 2011 он.
- Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагааны талаарх нэгдсэн танилцуулга. УБ., 2019 он.
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://www.legalinfo.mn/additional/?lawid=356>

## Хуралдааны тэмдэглэл

- Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 05, 11, 12, 18, 19, 26-ны өдрүүдийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл. Эх сурвалж: [www.parliament.mn](http://www.parliament.mn)

## УИХ-ын Тамгын газрын архивын нэгж

- Данс 4, ХН 207.
- Данс 4, ХН 336.
- Данс 4, ХН 399.
- Данс 5, ХН 288.
- Данс 6, ХН 739.
- Данс 7, ХН 812.